“МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБОО”
БАТЛАВ
ТЭРГҮҮН ..... А.БАТДАВАА

ПАРАГЛАЙДИНГИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь параглайдингийн спортын шүүлтийн үйл ажиллагааг олон улсын стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, шүүгчдийн эрх зүйн байдал, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү дүрмээр Монголын Параглайдингийн холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны Шүүгчдийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, шүүгчийн эрх, үүрэг, мэргэшлийн түвшин, ёс зүй, сахилгын хариуцлага, ажлын хөлс болон түүнтэй холбоотой харилцааг баталгаажуулна.

1.3. Энэхүү дүрмийг Холбоо, түүний харьяа клуб, тэмцээн зохион байгуулагч болон параглайдингийн спортын шүүгч нар дагаж мөрдөнө.

1.4. Шүүгчдийн зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны холбогдох FAI/CIVL Accuracy Landing Sporting Code болон тэмцээний нэмэлт дүрэмд бүрэн нийцсэн байна.

1.5. Шүүгч нь хараат бус, шударга, төвийг сахисан байр суурь баримталж, аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд хангаж ажиллана.

1.6. Параглайдингийн тэмцээний шүүлт нь нислэгийн аюулгүй ажиллагаа, спортын шударга өрсөлдөөн, тамирчдын эрх ашгийг хамгаалах үндсэн зарчимд тулгуурлана.

ХОЁР. ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛ

2.1 Параглайдингийн спортын тэмцээн шүүх эрх бүхий, Холбооноос эрх олгогдсон иргэнийг параглайдингийн шүүгч гэнэ.

2.2 Шүүгч нарыг “Параглайдингийн Шүүгчдийн Зөвлөл” болгон зохион байгуулна.

2.3 Шүүгчдийн зөвлөл нь Холбооны дэргэд үйл ажиллагаа явуулах бөгөөд дотоод зохион байгуулалтаа бие даан хийнэ.

2.4 Шүүгчдийн зөвлөл дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 2.4.1 Шүүгчийн сургалт зохион байгуулах;
- 2.4.2 Шинэ шүүгч бэлтгэх;
- 2.4.3 Шүүгчдийн мэргэшлийн түвшин тогтоох;
- 2.4.4 Тэмцээний шүүлтийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- 2.4.5 Аюулгүй ажиллагааны стандартыг мөрдүүлэх;
- 2.4.6 Шүүгчдийн мэдээллийн сан, бүртгэл хөтлөх;
- 2.4.7 Олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- 2.4.8 Шүүгчийн ёс зүй, сахилгын асуудлыг хэлэлцэх.

2.5 Шүүгчдийн зөвлөл жилд хоёроос доошгүй удаа хуралдана.

2.6 Шүүгчдийн зөвлөлийн шийдвэрийг хурлын ирцийн олонхийн саналаар батална.

2.7 Шүүгчдийн зөвлөлийн ахлахыг Холбооны Удирдах зөвлөл томилно.

ГУРАВ. ШҮҮГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Шүүгч нь 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай байна.

3.2 Шүүгч нь Шүүгчдийн зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд хамрагдаж, шалгалтад тэнцсэн байна.

3.3 Шүүгч нь параглайдингийн спортын дүрэм, аюулгүй ажиллагааны мэдлэгтэй байна.

3.4 Шүүгч нь ёс зүйн шаардлага хангасан байна.

3.5 Шүүгч нь эрүүл мэндийн хувьд үүргээ гүйцэтгэх чадвартай байна.

ДӨРӨВ. ШҮҮГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Шүүгч дараах эрхтэй:

4.1.1 Тэмцээний дүрмийн хүрээнд хараат бус шийдвэр гаргах;

4.1.2 Нислэгийн үр дүнг баталгаажуулах;

4.1.3 Дүрмийн зөрчил илэрсэн тохиолдолд тайлбар шаардах;

4.1.4 Нотлох баримт (видео, зураг, мэдүүлэг)-ыг ашиглах;

4.1.5 Оноо, шийдвэрийг түр хугацаагаар түдгэлзүүлэх;

4.1.6 Дахин хэмжилт хийхийг шаардах.

4.1.7 МПХ-ны ёс зүйн дүрмийн ноцтой зөрчил гаргасан тамирчин, нисгэгчийг тус тэмцээнээс хасах, онцгой тохиолдолд нэг жилийн хугацаанд гадаад болон дотоодын тэмцээнд оролцох эрхийг хасах саналыг МПХ-нд гаргах

4.2 Аюулгүй ажиллагааны эрх:

4.2.1 Нислэгийг түр зогсоох санал гаргах;

4.2.2 Цаг агаарын нөхцөл аюултай гэж үзвэл старт хаах хүсэлт гаргах;

4.2.3 Осол, эрсдэл үүссэн тохиолдолд нислэгийг зогсоох;

4.2.4 Safety Director-той хамтран шуурхай арга хэмжээ авах.

4.3 Шүүгч дараах үүрэгтэй:

4.3.1 FAI, CIVL болон Холбооны дүрмийг мөрдөх;

4.3.2 Шударга, хараат бус ажиллах;

4.3.3 Аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд хангах;

4.3.4 Цаг уурын нөхцөлд бодит үнэлгээ хийх;

4.3.5 GPS tracklog болон scoring мэдээллийг үнэн зөв боловсруулах;

4.3.6 Осол, зөрчлийн талаар шуурхай тайлагнах;

4.3.7 Тэмцээний үеэр согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байх;

4.3.8 Шүүлтийн ур чадвараа тогтмол хөгжүүлэх.

4.4 Сахилгын эрх

4.4.1 Тамирчинд анхааруулга өгөх;

4.4.2 Зөрчил гаргасан оролцогчийг тэмцээний дүрмийн дагуу торгох санал гаргах;

4.4.3 Ноцтой зөрчил гаргасан тохиолдолд Chief Judge-д дисквалификацийн санал хүргүүлэх.

ТАВ. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ

5.1 Шүүгч нь шударга, төвийг сахисан байр суурь баримтална.

5.2 Тамирчин, баг, клубт давуу байдал олгохыг хориглоно.

5.3 Шүүгч нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

5.4 Шүүгч нь тэмцээний нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйлдэл гаргахгүй.

5.5 Шүүгч нь бусад шүүгч, тамирчин, зохион байгуулагчтай хүндэтгэлтэй харилцана.

ЗУРГАА. ШҮҮГЧИЙН МЭРГЭШЛИЙН ТҮВШИН

6.1 Шүүгчийн мэргэшлийн түвшин дараах ангилалтай байна:

- Дадлагажигч шүүгч
- Холбооны шүүгч
- Олон улсын шүүгч

6.2 Мэргэшлийн түвшин тогтоох журмыг Шүүгчдийн зөвлөл батална.

6.3 Олон улсын шүүгчийн зэрэг нь FAI/CIVL-ийн шаардлагад нийцсэн байна.

ДОЛОО. ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛ

7.1 Шүүгч нь дараах албан тушаалд ажиллаж болно:

- Chief Judge (Ерөнхий шүүгч)
  Гүйцэтгэх ажил:
  Шүүгчдийн баг (Event Judge, Target Judge гэх мэт)-ийг удирдах, зохион байгуулах.
  FAI/CIVL-ийн дүрэм, стандарт мөрдөгдөж байгаа эсэхийг хянах.
  Шүүлтийн явцын чанар, шударга байдлыг баталгаажуулах.
  Маргаан, гомдол, эсэргүүцлийг шийдвэрлэх эсвэл эцэслэн дүгнэх.
  Тэмцээний албан ёсны үр дүнг баталгаажуулах.
  Safety Director болон тэмцээний удирдлагатай уялдаа холбоотой ажиллах.
  Аюулгүй байдал, шүүлтийн нөхцөл хангалтгүй бол тэмцээнийг түр зогсоох санал гаргах..
- Event Judge (Тэмцээний шүүгч)
  Гүйцэтгэх ажил:
  Тэмцээний өдөр тутмын шүүлтийн ажиллагааг зохион байгуулах.
  Target Judge нарт үүрэг хуваарилах, чиглүүлэх.
  Хөөрөлт–нислэг–буултын үйл ажиллагааны уялдааг хангах.
  Бай (target), хэмжилтийн төхөөрөмж, шүүлтийн бэлэн байдлыг шалгах.
  Safety Director болон Chief Judge-тэй уялдаа холбоотой ажиллах.
  Салхи, цаг агаарын нөхцлөөс хамаарч ажиллагааг түр зогсоох санал гаргах.
  Шүүлтийн явцад гарсан асуудлыг газар дээр нь шийдвэрлэх.
- Safety Director (Аюулгүй ажиллагааны шүүгч)
  Гүйцэтгэх ажил:
  Тэмцээний талбай, хөөрөлт болон буултын бүсийн аюулгүй байдлыг үнэлэх.
  Цаг агаар, салхины нөхцөл байдалд тасралтгүй хяналт тавих.
  Нислэг эхлэх, түр зогсоох, цуцлах талаар аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргах.
  Онцгой байдал, ослын үед аврах ажиллагааг зохион байгуулах.
  Эмнэлгийн болон аврах багийн бэлэн байдлыг хангах.
  Тэмцээний аюулгүй ажиллагааны дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих.
  Аюултай нөхцөл илэрсэн тохиолдолд тэмцээний удирдлагад мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авах.
  Осол, зөрчлийн талаар тайлан гаргаж, урьдчилан сэргийлэх санал боловсруулах.
- Launch Marshal (Гарааны шүүгч)
  Гүйцэтгэх ажил:

Хөөрөлтийн талбайн аюулгүй байдлыг хангах.
Нисгэгчдийг хөөрөх дарааллын дагуу бэлэн байлгах.
Салхины нөхцөл болон хөөрөлтийн бүсийн аюулгүй байдлыг хянах.
Нисгэгчийн тоног төхөөрөмж, далавчны бэлэн байдлыг нүдээр шалгах.
Хөөрөлтийн талбайд хэт бөөгнөрөл үүсэхээс сэргийлж хөдөлгөөнийг зохицуулах.
Safety Director болон Meet Director-той холбоотой ажиллах.
Аюултай нөхцөл үүсвэл хөөрөлтийг түр зогсоох эсвэл хойшлуулах санал гаргах.
Хөөрөлтийн талбайд зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл нэвтрэхээс сэргийлэх.

- Scorer / Recorder (Оноо бүртгэгч)

Гүйцэтгэх ажил:

Шүүгчдийн өгсөн оноог үнэн зөв бүртгэх.
Тойрог бүрийн үр дүнг нэгтгэж боловсруулах.
Нисгэгчдийн оноо, байр эзлэлтийг тооцоолох.
Урьдчилсан болон албан ёсны дүнг гаргах.
Онооны мэдээллийн сан, программ хангамжийг хөтлөх.
Дүнгийн алдаа, зөрүүг шалгаж баталгаажуулах.
Ерөнхий шүүгч болон тэмцээний удирдлагыг онооны мэдээллээр хангах.
Тэмцээний эцсийн тайлан, үр дүнг бэлтгэх

- Target Judge (Цэгийн шүүгч)

Гүйцэтгэх ажил:

Нисгэгчийн эхний буултын цэгийг тодорхойлох.
Буултын үед унасан (fall) эсэхийг тогтоох.
Бай дээрх буултын алсын зайг хэмжиж оноо өгөх.
Оноог Scorer-т 3 удаа давтан хэлж бүртгүүлэх.
Дүрмийн дагуу шударга, нэгэн жигд шүүлт хийх.
Event Judge-д мэдээлэл дамжуулах.
Маргаантай тохиолдолд нотолгоонд суурилсан мэдээлэл өгөх.

НАЙМ. ШҮҮГЧИЙН АЖЛЫН ХӨЛС, УРАМШУУЛАЛ

8.1 Шүүгчийн ажлын хөлсийг тэмцээний цар хүрээ, тэмцээнд оролцогдын тоо, тэмцээний чансаа, тэмцээний оролцогч тус бүрийн татварын хэмжээ, хариуцлага, эрсдэлийн түвшинг харгалзан тогтооно.

8.2 Шүүгчид дараах төрлийн хөлс, урамшуулал олгож болно:

- Сургалтын хэлбэр
- Багийн event
- Бусад

8.3 Шүүгчийн ажлын хөлсний хэмжээг Шүүгчдийн зөвлөлөөс баталсан тарифын дагуу тооцно.

8.4 Олон улсын тэмцээнд ажилласан шүүгчид нэмэгдэл урамшуулал олгож болно.

8.5 Тэмцээнийг дундаас орхисон, ноцтой зөрчил гаргасан тохиолдолд ажлын хөлсийг хэсэгчлэн буюу бүтэн олгохгүй байж болно.

ЕС. ШҮҮГЧИЙН ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛГОХ

9.1 Шүүгчтэй байгуулсан гэрээг дараах үндэслэлээр дуусгавар болгож болно:

- Гэрээний хугацаа дууссан;

- Өөрийн хүсэлт гаргасан;
- Ёс зүйн ноцтой зөрчил гаргасан;
- Аюулгүй ажиллагааны шаардлага ноцтой зөрчсөн;
- Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн нь тогтоогдсон;
- Холбоо болон шүүгчийн зөвлөлийн нэр хүндэд ноцтой хохирол учруулсан.

9.2 Шүүгчийн гэрээг дуусгавар болгох асуудлыг Шүүгчдийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Холбооны Удирдах зөвлөлийн шийдвэрээр баталгаажуулна.

9.3 Шүүгч нь өөрийн тайлбар, баримтыг гаргах эрхтэй.

9.4 Шүүгчийн үнэмлэх, шүүгчийн зөвлөлийн эд хөрөнгийг 14 хоногийн дотор буцаан хүлээлгэн өгнө.

АРАВ. САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭ

10.1 Дараах тохиолдолд сахилгын арга хэмжээ авна:

- Дүрэм зөрчих;
- Ёс зүйн зөрчил гаргах;
- Аюулгүй ажиллагааны шаардлага биелүүлэхгүй байх;
- Шүүлтийн ноцтой алдаа гаргах.

10.2 Сахилгын арга хэмжээ нь:

- Сануулах;
- Эрхийг түр түдгэлзүүлэх;
- Шүүгчийн эрх хасах.

10.3 Шүүгчийн эрх хасах асуудлыг Холбооны Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

АРВАН НЭГ. БУСАД

11.1 Энэхүү дүрмийг Холбооны Удирдах зөвлөл батална.

11.2 Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Шүүгчдийн зөвлөлийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

11.3 Энэхүү дүрэм батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Дүрэм баталсан

МПХ Удирдах зөвлөлийн гишүүд:

А.Батдаваа

Н.Мөнхбаяр

С.Очхүү

П.Бэхболд

Ц.Мягмардорж

Б.Болормаа

П.Болд

Б.Дарамжав

Г.Мөнхсайхан